



СҮХБААТАР АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО-Д

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024.08.08 № 439
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Ардчилсан намын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

Сүхбаатар Аймгийн Ардчилсан намын
хорооны 2024 оны 6 дугаар сарын 23 -ны
өдрийн 02 дүгээр тогтоолын хавсралт



СҮХБААТАР АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН 2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сүхбаатар аймгийн Ардчилсан нам “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хөгжлийн хөтөлбөр, “Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2020-2028”, Намын дүрэм, үнэт зүйлс, үзэл баримтлал, Таван тулгуур бодлого болон олон нийтийн санаа бодолд үндэслэн иргэд сонгогчдынхоо итгэл дэмжлэгээр бодлогоо хэрэгжүүлж хүрсэн амжилтдаа тулгуурлан, 2024-2028 оны аймгийн ИТХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хүргэж байна.

1. ЭРҮҮЛ МЭНД

1.1. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл амьдралын дадлыг хэвшүүлэн, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх замаар хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

1.2. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадлыг эзэмшүүлэн, иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлнэ.

1.3. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд дэмжиж ажиллана.

1.4. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.

1.5. Эрүүл мэндийн зарим тусламж үйлчилгээг иргэн, төрийн байгууллага, хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааны оролцоотой зохион байгуулж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэн үр дүнг тооцож ажиллана.

1.6. Эрүүл мэндийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно.

1.7. Мэдээллийн технологид суурилсан оношилгооны хэлбэрүүдийг нэвтрүүлж, Эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийг эрчимжүүлнэ.

1.8. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжиж, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг 7- болгож, багасгана.

1.9. Иргэдэд зонхилон тохиолдож буй өвчлөлийн эсрэг “Элэг бүтэн Сүхбаатар” хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж, өвчлөлийг бууруулна.

1.10. Яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээг тэлж, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлэх замаар иргэдэд ойр болгоно.

1.11. Шүдний эмчийг үе шаттай бэлтгэж, бүх сумдын эрүүл мэндийн төв, зарим сумдын Ерөнхий боловсролын сургуулийг шүдний кабинеттай болгоно.

1.12. Архи тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, буруу хооллолт, амьдралын буруу хэв маяг, дадал зуршлыг бууруулахад чиглэсэн мэдээлэл сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.

1.13. Эмийн чанарт тавих хяналтыг сайжруулж, аюулгүй байдлыг ханган, эмийн хэрэглээний зохистой дадлыг хэвшүүлнэ.

1.14. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг сайжруулан, нийгмийн хамгааллыг бэхжүүлнэ.

1.15. Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад улсад суралцах, туршлага судлахад дэмжлэг үзүүлж, шаардлагатай нэр төрлөөр мэргэшсэн эмч нарыг орон нутагт зөвлөхөөр ажиллуулна.

1.16. Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар нэр хүнд, ёс зүйд тавигдах шалгуурыг боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

1.17. Эрүүл аюулгүй ажлын байрыг дэмжих зорилгоор ажил олгогчдод чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН

2.1. Сургууль, цэцэрлэгийг орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмжөөр хангаж, боловсролын чанарт ахиц гаргана.

2.2. Хүүхэд бүрийг сургууль, цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлж, чанартай боловсрол олгоно.

2.3. Орон нутагт хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг байгуулах санал, санаачилгыг дэмжинэ.

2.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, МСҮТ-д “Эмч”, “Сэтгэл зүйч” ажиллуулахад дэмжиж ажиллана.

2.5. Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулж, халуун ус, угаалгын үйлчилгээ, номын сан, хүүхэд хөгжлийн танхим, тоглоомын өрөөтэй болгоно.

2.6. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын “Үдийн цай”, “Сүү” хөтөлбөрт эрүүл мэндийг дэмжих зорилгоор орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.

2.7. Мэдээллийн технологид суурилсан сургалтын арга зүйг нэвтрүүлнэ.

2.8. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүүхэд бүрд компьютер” хөтөлбөр хэрэгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.

2.9. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэхэд шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

2.10. Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, иргэн бүрийн насан туршдаа суралцахуйн хэрэгцээ шаардлага нийцсэн сургалтыг чанартай зохион байгуулна.

2.11. Мэргэжлийн боловсрол сургалтын төв, дотуур байр, цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

2.12. Мэргэжлийн боловсролын сургалтын төв, дотуур байр, цэцэрлэг, сургуулийг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

2.13. Бүх нийтийн Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

2.14. Мэргэжлийн боловсрол сургалтын төвд орон нутгийн хөдөлмөрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

2.15. Мэргэжлийн боловсрол, сургалтын төвийн суралцагчдыг дадлагажуулах байртай болоход дэмжлэг үзүүлнэ.

2.16. Мэргэжлийн боловсрол, сургалтын төв, Ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай мэргэжлээр зөвлөх, зочин, ментор багш ажиллуулж, “БАГШ СОЛИЛЦОО” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.17. “ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХ СҮХБААТАРЧУУД” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.18. Орон нутагт инновац, шинэлэг санаа нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжинэ.

2.19. Орон нутагт их, дээд сургууль байгуулах чиглэл баримтална

2.20. Багшийн мэргэжлийн ур чадвар нэр хүнд, ёс зүйд тавигдах шалгуурыг боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

2.21. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлж, гадаад, дотоод туршлага судлуулна.

2.22. Багшийн хөгжлийн төв байгуулж багш нарыг мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангаж ажиллана.

2.23. Орон нутгийн баг, тамирчдыг улсын болон олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцоход бодлогоор дэмжиж ажиллана.

2.24. Ирээдүйд багшийн мэргэжил эзэмших чин хүсэлтэй сурагчдын нэгдэл “Багш сонгон”-ы үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.25. Олон улсад мэргэжил дээшлүүлэх, сургуульд суралцахад орон нутагтаа гадаад хэлний сургалтад хамрагдах боломжоор хангаж, зуучилна.

3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3.1. Өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

3.2. Ажил олгогчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг бүрэн хангах мэргэжилтэн бэлтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3. Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гэрээ, хэлэлцээрийг бүх шатанд байгуулж, үр дүнг нэмэгдүүлнэ.

3.4. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

3.5. Инновацид суурилсан гарааны бизнесийг дэмжинэ.

3.6. Тусгай хэрэгцээт иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч бэлтгэнэ.

3.7. Байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөлөл, малчдын эрэлт, хэрэгцээ, шаардлагатай уялдуулан “Малжуулах” төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.8. Төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний газар, нийтийн эзэмшлийн зам талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг нэмэгдүүлж, хүртээмжийг дээшлүүлнэ.

4. СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР

4.1. Өсвөр үе залуучуудыг спортын олон төрлөөр хичээллэж бие бялдраа хөгжүүлэх, спортын амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2. Сумдад стандартын шаардлага хангасан чийрэгжүүлэлт, биеийн тамирын задгай талбай, байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.3. Улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагт жилд 2-оос төрлөөр зохион байгуулж, өсвөр үе залуучууд, иргэдэд сурталчилна.

4.4. Үндэсний спортын наадам, Хүүхдийн спортын наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

4.5. Өвлийн улиралд нийтийн биеийн тамираар хичээллэх спорт клубийг дэмжинэ.

4.6. Сумдад Нийтийн биеийн тамирын арга зүйчийг ажиллуулахад дэмжиж ажиллана.

5. СОЁЛ УРЛАГ

5.1. Стандарт шаардлага хангасан соёл, урлагийн барилга байгууламжийг нэмэгдүүлнэ, соёл урлагийн салбарын мэргэшсэн боловсон хүчний хангалтыг сайжруулна.

5.2. Аймгийн соёл урлаг, өв соёлыг хөгжүүлэх, сурталчлан таниулах, хамгаалахад чиглэсэн соёл урлагийн хөгжлийн хөтөлбөр, төслийг хэрэгжүүлнэ.

5.3. Монгол хүн үндэсний өв соёлоороо бахархах өвлүүлэх, үндэсний хэл бичигт суралцахыг дэмжинэ.

5.4. Аймгийн хэмжээнд угийн бичиг хөтлөлтийн хувийг 70+ хувьд хүргэнэ.

5.5. Бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин, соёл урлагийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.

5.6. Нүүдлийн ахуйд суралцах өв соёлын түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ, хөтөлбөрүүдийг дэмжинэ.

5.7. Угсаатны онцлогийг илэрхийлсэн гар урлалын брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, зах зээлд нэвтрүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.

5.8. Сумдын соёлын төвийг лед дэлгэцээр бүрэн хангана.

6. ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ЗАЛУУЧУУД

6.1. Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох Монгол гэр бүл боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.2. “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-ийг стандартын дагуу байгуулж, зорилтот гэр бүлд чиглэсэн үйлчилгээг өргөжүүлнэ.

6.3. Хохирогчийг хамгаалах “Түр хамгаалах байр”-ны үйлчилгээг өргөжүүлж, хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчийг хамгаалах, нөхөн сэргээх болон хөгжлийн зэрэг хариу үйлчилгээг нэмэгдүүлнэ.

6.4. Стандартын шаардлага хангасан Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төвийг байгуулж, залуучуудын хөгжил оролцоог дэмжинэ.

6.5. Залуучуудад чиглэсэн зарим үйлчилгээг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэн залуучуудын үйлчилгээнд хамрагдалтыг 50 хувиар нэмэгдүүлнэ.

6.6. Өсвөр насны хүүхдүүдэд “Технологийн боловсрол олгох, ур чадвар олгох” төслийг хэрэгжүүлнэ.

6.7. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр дагнан ажиллах хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан сумдад мэргэшүүлэхэд санал санаачилга гаргаж дэмжиж ажиллана.

6.8. “Хүүхдэд ээлтэй байгууллага, аж ахуйн нэгж”-ийг шалгаруулах болзолт уралдааныг дүгнэж, жил бүр шалгаруулна.

6.9. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн “Хүүхдийн залуучуудын хөгжлийн төв”-г байгуулна.

6.10. Нялх, нярай хүүхэдтэй эцэг, эхчүүдийн зорчих дэд бүтцийг бүрэн шийдвэрлэнэ.

7. ЭДИЙН ЗАСАГ

7.1. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

7.2. Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож сахилга хариуцлагыг сайжруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.

7.3. Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгон төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

7.4. Газар, үл хөдлөх эд хөрөнгө, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн бүртгэлийг сайжруулж, татварын хувь хэмжээг бууруулах замаар татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

7.5. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ.

7.6. Банкнаас бусад олон талт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

7.7. Статистик мэдээллийн хамрах хүрээ, тооллого, судалгааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

8. УУЛ УУРХАЙ

8.1. Уурхайн үйл ажиллагааны хяналт, нөхөн сэргээлт, хаалтын стандартыг олон улсын жишигт хүргэж, дүйцүүлсэн нөхөн сэргээлтийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулна.

8.2. Уул уурхайн ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах, байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор бүтээгдэхүүн тээвэрлэлтийн экспортын хүнд даацын авто зам барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

8.3. Уурхайг ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл

эзэмшигч нартай нутгийн захиргааны байгууллага хамтран ажиллах гэрээ байгуулж, дүгнэж ажиллана.

8.4. Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хүрээнд хүнд үйлдвэр байгуулах төслүүдийн үйл ажиллагааг орон нутгаас бодлогоор дэмжин хамтран ажиллана.

8.5. Байгалийн баялгаас орж буй орлого, төсөв, тендерийг иргэдээр хэлэлцүүлдэг тогтолцоог шинэ шатанд гаргаж, иргэдийн оролцоог хангана.

9. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

9.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өргөжүүлэн, малын эрүүл мэндийг хамгаалж, малын ашиг шимийг дээшлүүлнэ.

9.2. Тариалангийн газрын талбайн ашиглалтыг сайжруулан, тариалалтыг нэмэгдүүлнэ.

9.3. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээний 50-аас доошгүй хувийг хангана.

9.4. Газар тариалангийн зориулалт бүхий техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлнэ.

9.5. Хөрс, цаг уурын онцлогт тохирсон баталгаат сортын үрийн хангамж, тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

9.6. Өрх, байгууллага бүр хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, Нийлэг хальсан хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлж, жимс жимсгэнэ, нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ.

9.7. Хүнсний үйлдвэр, нийтийн хоолны аюулгүй байдалд хяналт тавьж эрсдэлийг бууруулна.

9.8. Бэлчээрийн мэргэч амьтан үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг зохион байгуулж, усжуулах, хамгаалах, нөхөн сэргээх замаар нөөц бэлчээрийг нэмэгдүүлнэ.

9.9. Бэлчээрт ашиглаж байгаа, инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг шинээр гаргаж ашиглахгүй байгаа худгуудыг шат дараатай сэргээн засварлана.

9.10. Сум дундын болон сумын отрын бүс нутгийг тогтоох, хил заагийг тодорхойлж баталгаажуулна.

9.11. Хадлангийн талбайг үе шаттай хашиж хамгаалан эрсдэл бүхий нөхцөлөөс урьдчилан сэргийлэх тохиолдол бий болсон үед малчдад худалдан борлуулж, эргэлтэд оруулах зорилготой өвс, тэжээлийн нөөцийн фондын тогтолцоог бий болгоно.

10. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

10.1. Хоршоо хөгжүүлэх сан, ЖҮД сан, Төсөл хөтөлбөрийн хүрээн дэх хөнгөлөлттэй зээл олголтыг орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан олгож, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

10.2. Аймгийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр бүрэн хангах, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.

10.3. Мах, ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах аж ахуй нэгжийн санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжинэ.

10.4. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.

10.5. Орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, хоршоодын бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог кластерын системээр хөгжүүлнэ.

10.6. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг олон улсын жишигт хүргэнэ.

10.7. Хот, суурин газрын хүнсний нийтийн хэрэглээний малыг зөвхөн үйлдвэрийн аргаар нядалж боловсруулах стандартыг бүрдүүлж, энэ чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ

10.8. Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

10.9. Хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих, хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

10.10. Дэвшилтэт техник, өндөр технологи, инновацад суурилсан дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

10.11. Шинэ технологи, инновацын ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээг хөгжүүлнэ.

10.12. Оюуны өмчийн патент, чанар стандартын баталгаатай орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ.

11. МАЛ АЖ АХУЙ

11.1. Бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж болон мэргэжилтний хяналтад төвлөрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж өсвөр хээлтүүлэгч худалдан авч малын чанарыг сайжруулна.

11.2. “Хариуцлагатай, чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

11.3. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах, хээлтүүлэгч болон цөм сүргийн малыг мэргэжлийн байгууллагын хяналтад авах,

малын генетик нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан нэгж малаас авах ашиг шимийг дээшлүүлнэ.

11.4. Өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үүлдрийн үхэр, мах ноосны чиглэлийн хонь, махны чиглэлийн гахай, өндөгний чиглэлийн шувууны эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, ашиг шимийг нь нэмэгдүүлнэ.

11.5. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийг бодлогоор дэмжиж төв суурин газрын иргэдийн сүү, мах, өндөгний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор төрөлжсөн фермерүүдийг байгуулна.

11.6. Малын гоц халдварт, халдварт, зооноос, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлж, малын өвчнөөр тайван бүсийг тогтооно.

11.7. Халдварт зооноос өвчний гаралтыг багасган уг өвчнөөр тайван, халдваргүй бүсээр баталгаажуулна.

11.8. Сум дундын мал эмнэлэг, ариун цэврийн анхан шатны лаборатори байгуулна.

11.9. Үндэсний өв соёлыг хадгалсан Морин уралдааны тойруулгын төвийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

12. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

12.1. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн дулаарал, агаарын бохирдол, хөрсний талхагдал, цөлжилт зэрэг асуудлуудтай дорвитой тэмцэх, байгаль орчныг нөхөн сэргээхэд зарцуулж байгаа зардлын хэмжээг нэмэгдүүлнэ.

12.2. Орон нутгийн гамшгийн нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээг бүх түвшинд хийж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.

12.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

12.4. Ойн сан бүхий газрын ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ болон төв суурин газрын ногоон байгууламжийн ургалтыг хувийг нэмэгдүүлж, Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

12.5. Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

12.6. Ховордсон биологийн төрөл зүйлийн нөөцийг хамгаалж, сэргээн нутагшуулна.

12.7. Халиун бугын Илий, Монгол тарвага сэргээн нутагшуулах ажлыг нэмэгдүүлнэ.

12.8. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалж, булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах, усны сан бүхий газарт хөв цөөрөм, усны сан байгуулна.

12.9. Айл өрхийн эко шийдлээр хийгдсэн 00-ын тоог иргэн болон хувийн хэвшлийн оролцоотойгоор нэмэгдүүлнэ.

12.10. Баруун-Урт суманд хог хаягдлыг бүрэн шатаах өндөр температурын зуухыг ашиглалтад оруулна.

12.11. Айл өрхийн хашаандаа мод тарих нөхцөл боломжийг бүрдүүлж "Нэг өрх-10 мод" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

13. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

13.1. Аялал жуулчлалын бүс бүрд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, нүүдлийн соёл иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал, шувуу ажиглах, язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ зохион байгуулна.

13.2. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх гадаад жуулчдын урсгалыг нэмэгдүүлнэ.

13.3. Эрдэнэцагаан суман дахь 80 ортой зочид буудлыг бүрэн ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

13.4. Дарьганга сумын БЦГ болох Талын агуйг шар усны үер, борооны уснаас хамгаалах тохижилтын ажлыг хийнэ.

13.5. Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын Донгойн ширээ түүх соёлын дурсгалыг түшиглэн Ил музей байгуулна.

13.6. Хүн чулуун хөрөг галерей байгуулж, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалалтад авна.

13.7. Сүхбаатар аймгийн Дарьганга суманд тахилгат хайрхад, хүн чулуун хөрөгт түшиглэсэн байгаль, соёлын өвийн цогцолбор байгуулна.

13.8. Дарьганга сумын Ганга нуурын шувуу ажиглах судалгаа шинжилгээний төв байгуулна.

13.9. Аялал жуулчлалын бүс нутагт эко ариун цэврийн байгууламж /ОО/ байгуулна.

13.10. Мөнххаан, Асгат суманд авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах үйлчилгээний цогцолбор шинээр байгуулна.

13.11. Дарьганга суманд жуулчдад зориулсан нийтийн байгальд ээлтэй ариун цэврийн байгууламж байгуулна.

13.12. Дарьганга, Эрдэнэцагаан, Онгон суманд цэвэрлэх байгууламж байгуулна.

14. ТЭЭВЭР, ЛОГИСТИК

14.1. Баруун-Урт - Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай хүнд даацын авто зам барих ажилд орон нутгаас дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

14.2. Евро - Азийн эдийн засгийн коридорт холбогдох зүүн бүсийн босоо тэнхлэг Эрээнцав боомт-Чойбалсан-Хөөт-Бичигт боомт чиглэлийн 588 км төмөр замыг барихад орон нутгаас дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

14.3. Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлж, санал санаачилга гарган хамтран ажиллана.

14.4. Бичигт боомт хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан тээвэр логиستيкийн төв байгуулах ажлыг эхлүүлнэ.

14.5. Бичигт боомтын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

14.6. Аялал жуулчлалын бүс Дарьганга чиглэлийн хатуу хучилттай авто зам барих ажлыг санаачлан хэрэгжүүлэхэд орон нутгаас хамтран ажиллана.

14.7. Аймгийн онцгой комиссыг онцгой нөхцөл байдалд ашиглах техник, хэрэгслэлийн болон материаллаг баазыг сайжруулна.

15. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

15.1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын бодлогыг хот төлөвлөлттэй уялдуулж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

15.2. Аймгийн төвийн болон сумдын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

15.3. Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон сууцны барилга, хотхон, хороолол барих ажлыг сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлнэ.

15.4. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

15.5. Боловсрол Хотхон хорооллуудын доторх тохижилтын ажлыг төлөвлөн төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлж дуусгана.

15.6. Сумдад орчин үеийн шийдэлтэй боловсрол, соёл, спорт, сургууль цэцэрлэгийн барилгуудыг барьж нийгмийн хэрэгцээг хангана.

15.7. Орон нутгийн барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хайрганы карьер, ханын дүүргэгч хөнгөн блок, барилгын бетон хийц, асфальт бетон, хавтгай шилний үйлдвэр барих санал санаачилгыг дэмжинэ.

15.8. Аймгийн хэмжээнд хаягжилтын нэгдсэн системийг бүрдүүлнэ.

15.9. Дэд бүтцийн хангамжид тулгуурлан иргэнд газар өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тогтоож газрыг өмчлүүлнэ.

15.10. Төрийн болон орон нутгийн өмчийн барилгуудыг паспортжуулах, гэрчилгээжүүлнэ

15.11. Барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэлтийг тогтоож, чанарыг дээшлүүлнэ.

15.12. Сум, суурин газрын төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна.

15.13. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, сумдын ерөнхий төлөвлөгөө болон нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг хийж хэрэгжүүлнэ.

15.14. Аймаг, сумдын төвийн хүн амыг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан ундны усаар хангана.

15.15. Цэвэр усны хайгуул хийж, гүний худгийн тоог нэмэгдүүлнэ.

15.16. Түмэнцогт сум, Баруун-Урт хотын нийтийн хуучин орон сууцуудын дундын өмчлөлийн цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчилнэ.

15.17. Хуучин цэвэрлэх байгууламжийн лагийг боловсруулж үнэргүйжүүлнэ.

15.18. Аймгийн төвийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан дамжуулах 35/10кВ-ын ил хуваарилах байгууламжийг ашиглалтад оруулна.

16. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

16.1. Баруун-Урт хот: Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хот болгон хөгжүүлнэ.

16.2. Дэд төвийг байгуулна.

16.3. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна.

16.4. Гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулна.

16.5. 960 айлын орон сууцны хороолол төслийг хэрэгжүүлнэ.

16.6. Хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж, ажлыг эхлүүлнэ.

16.7. Иргэдийн амрах, зугаалах газар, бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд улсын болон орон нутгийн хэмжээнд хамтарч ажиллана.

16.8. Уртын голын дагуу тохижилтын ажлыг дуусгана.

16.9. Хүүхдийн парк байгуулах ажлыг санаачлан улсын болон орон нутгийн төсвийн хүрээнд хамтран хэрэгжүүлнэ.

16.10. Эко хороололд цэцэрлэгт хүрээлэн шинээр барьж, барилгачдын цэцэрлэгт хүрээлэнг сэргээн засварлана.

16.11. Баруун-Урт нисэх буудлыг нүүлгэн шилжүүлэх ажлыг санаачлан улсын болон орон нутгийн хэмжээнд хамтарч ажиллана.

16.12. Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

16.13. Аймгийн төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн, орчин үеийн шийдэлтэй болгон зохион байгуулж, ашиглалтыг сайжруулна.

16.14. Мэдээлэл холбооны суурь дэд бүтцийг өргөтгөнө.

16.15. Жавхлант хаус хороолол, Эко, Боловсрол, Жавхлант хорооллууд руу холбоо хангамжийн сувагчлал татаж, утастай болон утасгүй интернэтийн сүлжээнд холбоно.

16.16. Баруун-Уртын инженерийн шугам сүлжээг бүрэн шинэчлэл хийнэ.

17. Сумдын хөгжил

17.1. Мөнххаан, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Баруун-Урт сумдад 640 хүүхдийн сургууль, Түвшинширээ суманд 320 хүүхдийн сургуулийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулна.

17.2. Баруун-Урт, Онгон, Сүхбаатар сумдад 200 ортой, Баяндэлгэр Уулбаян

сумдад 150 ортой, хүүхдийн цэцэрлэгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулна.

17.3. Баяндэлгэр суманд 160 ортой, Мөнххаан, Халзан суманд 75 ортой дотуур байрыг шинээр ашиглалтад оруулна.

17.4. Хөрөнгө оруулалт царцаагдсан Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумдын 200 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, Баяндэлгэр сумын Соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулна.

17.5. Спорт цогцолбор төвд бие бялдрын түвшин тогтоох сорилын төвийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулна.

17.6. Аймгийн нийтийн номын сан, Угсаатны зүйн музей барилгыг улсын төсвийн төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулна.

17.7. Аймгийн болон орон нутгийн музейн үзмэрийн баяжилтыг хийхэд дэмжлэг үзүүлнэ. /Бодлогоор/

17.8. Аймгийн Жаахан шарга театрын барилгын их засвар хийнэ.

17.9. Сумдын соёлын төв, номын сангийн техник тоног төхөөрөмжийг үе шаттай шийдвэрлэнэ.

17.10. Асгат, Дарьганга, Наран, Онгон, сумын соёлын төвүүдийн лед дэлгэцтэй болгоно.

17.11. Баруун-Урт суманд өрхийн Эрүүл мэндийн төв, Баяндэлгэр, Онгон, Түвшинширээ, Уулбаян сумдын эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилга, Эрдэнэцагаан суманд эрүүл мэндийн төвийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулна.

17.12. Асгат сумын эрүүл мэндийн төвийн больницын барилгын их засвар, Дарьганга, Наран сумын эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын их засварын сум, орон нутгийн төсвөөр шийдвэрлэнэ.

17.13. Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгыг улс, орон нутаг, төслийн санхүүжилтээр шийдэж, иж бүрэн засварыг хийнэ.

17.14. Сумдыг төвлөрсөн ус, дулаан, ариутгах татуургын шугам сүлжээ, ариун цэврийн байгууламжийн хангамжтай болгох ажлыг улсын болон орон нутгийн төсвөөр шат дараалалтай хэрэгжүүлнэ.

17.15. Асгат, Уулбаян, Баяндэлгэр, Түвшинширээ, Мөнххаан сумдад төвлөрсөн халаалтын уурын зуух барина.

17.16. Дарьганга, Халзан, Асгат, Эрдэнэцагаан, Онгон, Сүхбаатар сумдыг цэвэр ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбож, цэвэрлэх байгууламж барина.

17.17. Сумдын дулаан хангамжийн эх үүсвэрийн өргөтгөл, шинэчлэлт хийнэ.

17.18. Алслагдсан сумдад агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ, ерөнхий зориулалтын нислэг үйлдэх зурвас газрыг тогтоож, хамгаалалтад авна.

17.19. Түмэнцогт, Асгат суманд цагдаагийн хэсгийн кобаны барилгыг барина.

17.20. Наран суманд 3.2 км хатуу хучилттай замыг барьж ашиглалтад оруулна.

17.21. Наран суманд Иргэдэд үйлчлэх төвийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж ашиглалтад оруулахад санал санаачилга гарган ажиллана.

18. НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛ

18.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж, хариуцлагыг дээшлүүлнэ.

18.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдүүлж, төрийн албанд хууль дээдлэх ухамсар, төлөвшлийг хэвшүүлнэ.

18.3. Төрийн байгууллага, нийгэм, эдийн засаг соёлын хүрээнд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендерийн бодлого хэрэгжүүлнэ.

18.4. Нутгийн захиргаан байгууллагын бүтэц, орон тоог оновчтой тодорхойлж мөрдүүлнэ.

18.5. Орон нутагт нэн шаардлагатай төрийн алба хаагчдыг боловсон хүчний судалгаанд үндэслэн шилжиж ирэхийг дэмжих зорилгоор Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үргэлжлүүлж тогтвор суурьшилтай ажиллахад дэмжинэ.

18.6. Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, цахим болон тоон гарын үсэг, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангана.

18.7. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сүлжээг бий болгоно.

18.8. Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлнэ.

18.9. Мэдээллийн технологи, харилцаа, холбооны хамрах хүрээг тэлэн, өндөр хурдны интернэт сүлжээг хүртээмжтэй болгож, иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахимжуулна.

18.10. Бүртгэл, архив, үндэсний дата системийн ухаалаг үйлчилгээг ашиглан Орон нутгийн төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулна.

18.11. Орон нутгийн гамшгаас хамгаалах техник тоног төхөөрөмжийг шинэчилж, гамшгийг даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлнэ.

18.12. Онцгой байдлын олон улсын аврах ажиллагаанд тогтмол оролцуулж, аврагчдын солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

18.13. Орон нутагт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр, гадаадын орнуудтай бүх талын хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлнэ.

18.14. Төрийн албан хаагчдыг дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.

18.15. Гадаад улсын муж хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

19. БАТЛАН ХАМГААЛАХ

19.1. Орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлж, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгоно.

19.2. Дайчилгааны төлөвлөгөөг шинэчилж, "Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн"-ийг чадавхжуулна.

19.3. Эх оронч үндэсний үзэл хүмүүжил, хүний хөгжил, төлөвшлийн орчин бүрдүүлнэ.

20. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

20.1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж, нийгмийн дэг журмыг тогтоох замаар иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бий болгоно.

20.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлнэ.

20.3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тогтмол, үр дүнтэй зохион байгуулж, хууль дээдлэх хандлагыг төлөвшүүлнэ.

19.4. Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, зорилтот бүлэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

20.5. Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангаж, хил хамгаалалтад орчин үеийн дэвшилтэд техник тоног төхөөрөмж, хяналтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлнэ.

20.6. Ногоон бүс" төслийг үргэлжлүүлж, бүх сумдыг хяналтын камерын нэгдсэн системд холбоно.

20.7. Иргэн бүрийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай мэдлэг, мэдээллийг нийгэмд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.

20.8. Хууль, хяналтын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, дэмжлэг үзүүлнэ.

20.9 Сумдын хэсгийн төлөөлөгч нарыг автомашинаар хангахад санал санаачилга гаргаж, дэмжиж ажиллана.

20.10 Олон нийтийн цагдаагийн орон тоог нэмэгдүүлнэ.

